МЭДЭЭ · 2024 оны 7-р сарын 2

ЭНЭ ОНЫ ХАГАС ЖИЛД БҮРТГЭГДСЭН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД ӨСЖЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

Улсын хэмжээнд **2024** оны II улиралд **1.469.780** зөрчлийн хэрэг бүртгэгдсэн.

ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС **4.3%**-ИАР ӨССӨН.

4.3%

Нийт зөрчлийн хэргийн **69.3%** нь Нийслэлд, **30.7%** нь орон нутагт гарсан бол дийлэнх буюу **85.8%** нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил байна.

69.3% Нийслэлд

30.7% Орон нутагт

ӨССӨН ЗӨРЧЛҮҮД

3862 **57%** Орон байранд бусдын амгалан тайван байдал алдагдуулж танхайрсан зөрчил

Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх зөрчил **6148** **31.6%**

6559 **14.8%** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил

Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил **61.421** **1.7%**

2024 ОНЫ II УЛИРАЛД **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ** ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ ХАМГИЙН ИХ БҮРТГЭГДСЭН.

103.829 **7.4%**

СОГТУУРСАН, МАНСУУРСАН ҮЕДЭЭ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДСОН ЗӨРЧИЛ **2023 ОНЫ II УЛИРАЛД 17.549** БҮРТГЭГДЭЖ БАЙСАН БОЛ **2023 ОНЫ II УЛИРАЛД 8.440** БҮРТГЭГДЭЖ, **52%**-ИАР БУУРСАН.



2024 ОНЫ II УЛИРАЛД ГАРСАН **1.469.780** ЗӨРЧЛИЙН **1.261.925 БУЮУ 85.8%** НЬ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ ЗӨРЧИЛ БАЙНА.

2024 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 1.469.780 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувиар өсжээ.

Нийт зөрчлийн хэргийн дийлэнх буюу 85.8 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил эзэлж байгаа бол 4.1 хувь нь Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 2 хувь нь Автотээврийн тухай хууль зөрчих, 0.6 хувь нь Хүний биед халдах зөрчил байна.

Үүнээс зонхилон үйлдэгддэг зарим төрлийн зөрчлийн хэргийн гаралт буурчээ. Тухайлбал, согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 52 хувиар, Хулгайлах зөрчил 12.7 хувиар тус тус буурсан байна.

Харин Орон байранд бусдын амгалан тайван байдал алдагдуулж танхайрсан зөрчил 57 хувиар, Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх зөрчил 31.6 хувиар, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 14.8 хувиар, Эд хөрөнгө устгах, гэмтээх зөрчил 8.4 хувиар, Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил 1.7 хувиар тус тус өсжээ.

Дээрх хугацаанд прокуророос зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан гомдол, мэдээллийг үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан 1320 шийдвэрийг хүчингүй болгож, үндэслэлгүйгээр шийтгэл оногдуулсан 2392 шийдвэрийг хүчингүй болгуулж, өөрчлөлт оруулахаар дүгнэлт бичиж, шүүхээр шийдвэрлүүлэн, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын зөрчигдсөн эрхийг сэргээсэн байна.

Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг хангуулахаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудад 131 шаардлага хүргүүлж, 253 албан тушаалтанд хариуцлага тооцуулжээ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН АЖЛЫН ЗАРИМ ТООН МЭДЭЭ:

Хяналт тавьсан зөрчлийн хэрэг **1.469.780**

Эрх бүхий албан тушаалтны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан **38.732** хянаад, үндэслэлгүйгээр шийдвэрлэсэн **1320** шийдвэрийг хүчингүй болгон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлсэн байна.

НИЙТ **4350** ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН.

ОРОН БАЙРАНД ҮЗЛЭГ ХИЙХ **0.6%**

МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧИГ ГАРГУУЛАН АВАХ **16.9%**

ХҮНИЙ БИЕД ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ **82.4%**

Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэрэгт үндэслэлгүйгээр оногдуулсан шийдвэрийг ХҮЧИНГҮЙ БОЛГУУЛАХААР **1621,**

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХААР **771** дүгнэлт бичиж шүүхээр шийдвэрлүүлэн, зөрчигдсөн эрхийг сэргээсэн байна.

Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор

228 шалгалт хийхэд

7.701 зөрчил илэрч,

131 прокурорын шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авчээ.

ПРОКУРОРЫН ШААРДЛАГЫН МӨРӨӨР **253** АЛБАН ТУШААЛТАНД САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ АВСАН БАЙНА.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1253